



**БУЛГАН АЙМГИЙН
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

Анхлагчдын өргөн чөлөө 1-120,
Жаргалант баг, Булган сум, Булган аймаг, 63082
Утас/Факс: 7034-2580
E-mail: bulgan@audit.gov.mn

2024.02.23 № 151

танай _____ ны № _____ т

**АЙМГИЙН ЗДТГ-ЫН ДАРГА
Д.АЛТАНШАГАЙ ТАНАА**

Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Аймгийн ЗДТГ-ын 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Асуудлыг онцолсон хэсэг

Аймгийн ЗДТГ нь 2023 онд орон нутгийн төсвөөс 4,272.5, нэмэлт санхүүжилтийн дансаар 3,439.9, үндсэн үйл ажиллагааны орлогоос 164.9 сая төгрөг буюу нийт 7,877.3 сая төгрөгийн санхүүжилт авч гүйцэтгэлээр 7,698.4 сая төгрөгийг зарцуулж үлдэгдэл 178.9 сая төгрөгийг төсөвт төвлөрүүлсэн байна.

Батлагдсан төсвийн хүрээнд байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөөгөөр 48 зорилтын хүрээнд 165 ажил төлөвлөснөөс гүйцэтгэлээр 153 ажил бүрэн, 12 ажил дутуу хэрэгжиж 96.1 хувиар үнэлэгдсэн байна.

Аудитын гол асуудал

Бидний мэргэжлийн шийдлийн дагуу аудитын гол асуудлууд гэж тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад хамгийн их нөлөөтэй асуудлуудыг үздэг. Санхүүгийн тайланд хийсэн аудитынхаа хүрээнд эдгээр асуудлуудыг нэгтгэсэн байдлаар авч үзсэн ба дүгнэлтээ гаргахдаа эдгээр асуудлуудад тус бүрчлэн

006020354

дүгнэлт гаргаагүй болно.

Аймгийн ИТХ-ын 2023 оны 01 дүгээр сарын 24-ний өдрийн XIII/08 тоот "Хөрөнгө бүртгэлд авах тухай" тогтоол, аймгийн Засаг даргын 2024 оны 01 дүгээр сарын 09-ний өдрийн А/10 тоот "Хөрөнгө бүртгэлд авах тухай" захирамж, байгууллагын даргын 2023 оны 06 дугаар сарын 28-ны өдрийн А/56 тоот тушаалыг үндэслэн оёдлын үйлдвэрийн барилгыг барилга, байгууламжийн дансанд 299.8, машин тоног төхөөрөмжийн дансанд 38.2, тавилга эд хогшлын дансанд 1.5 сая төгрөгийн үндсэн хөрөнгө орлогод авч шийдвэрээр 15.1 сая төгрөгийн машин тоног төхөөрөмж, тавилга эд хогшлыг данс бүртгэлээс хасаж тайлагнажээ.

Бусад асуудлын хэсэг

Архивын лавлагааны орлогыг 2023 онд 10.0 сая төгрөгөөр төлөвлөж, гүйцэтгэлээр 11.0 сая төгрөг буюу 1 сая төгрөгөөр илүү орлого оруулсан байна.

Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй ба үүнд ямар нэг төрлийн баталгаажуулах дүгнэлт гаргаагүй болно.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Б.ЭРДЭНЭ